



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар A/328

Есөнбулаг сум

“Угийн бичиг, удмын хэлхээз”  
хөдөлгөөн өрнүүлэх тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт, Засгийн Газрын 2007 оны 257 дугаар тогтоолоор батлагдсан “Угийн бичиг хөтлөх журам”-ын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Соёлын үнэт өв болох угийн бичгийг үеэс үед уламжлуулан хөтөлдөг зан үйлийг сэргээж өрх гэр булийн уг гарвал, ураг удмын холбоо, элгэн садны хэлхээгээ бэхжүүлэхэд нь дэмжих Монгол хүний удмын санд учирч болзошгүй цус ойртолтын эрсдэлээс сэргийлэх зорилгоор “Угийн бичиг, удмын хэлхээз” хөдөлгөөнийг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхний үе шат 2026 оны 11 дүгээр сард, 2 дугаар үе шат 2028 оны 09 дүгээр сард дүгнэхээр 2 үе шаттайгаар өрнүүлсүгэй.

2. Тус хөдөлгөөнийг өрнүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Төрийн байгууллагын албан хаагчид, ард иргэдийг хөдөлгөөнд нэгдэн өрх гэрийн угийн бичгээ хөтөлдөг болгохыг сумдын Засаг дарга, алба агентлагийн удирдлагуудад хариуцуулсугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг жилийн эцэст аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, ажиллахыг ажлын хэсэг (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ



Аймгийн Засаг даргын ..... оны  
.....дугаар сарын ..... -ны өдрийн .....дугаар  
захирамжийн хавсралт

**"УГИЙН БИЧИГ - УДМЫИН ХЭЛХЭЭ" ХӨДӨЛГӨӨНИЙГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн ахлагч: (Аймгийн Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)  
Нарийн бичгийн дарга (Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)  
(Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга)  
Гишүүд: (Аймгийн Боловсролын газрын дарга)  
(Насан туршийн боловсролын төвийн дарга)  
(Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын Соёл, урлагийн хэлтсийн дарга)  
(Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын Соёл, урлагийн газрын соёл гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)  
(Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын гэр бүлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)  
(Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)  
(Аймгийн Насан туршийн боловсролын төвийн багш)  
(Сумын Засаг дарга нар)  
(Сумын Соёлын төвийн дарга нар)  
(Аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд)

— ооо —

پسندیده بود - بیکار بدلیم می  
درست مخصوصاً دم بیکار



لذوق

三

$$\frac{70}{\text{hrs}} \quad \frac{70}{\text{hrs}} \quad \frac{7000}{\text{hrs}}$$

٢- بضم حاء وفتحاء ، بفتح حاء  
لهم لك رحمة نعمت بها ربنا ربنا محسن



دستگاه